



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/25

Сайнцагаан сум

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, Монгол Улсын Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалт, Хэлтсийн даргын 2013 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан “Ахмадын сангийн журам”-ын 3.14 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад орчин цагийн Цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний 101 жил, Дотоодын цэргийн 100 жил, Дундговь аймаг дахь цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойн баярыг угтаж ахмад настнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 4.046.900 /дөрвөн сая дөчин зургаан мянга есөн зуун / төгрөгийг ахмадын сангийн данснаас гарган зарцуулахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /цагдаагийн хошууч Т.Розон/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ